



ХОВД ИХ СУРГУУЛЬ
НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ
ГАДААД ХЭЛ, СОЁЛ СУДЛАЛЫН ТЭНХИМ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

(Бакалаврын түвшний сургалтад зориулав)

2022 он

Агуулга

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга	гарын үсэг Ц.Пүрэвсүрэн /тайлал/.....	2
Хэрэгцээ		3
Summary		3
Target student audiences		3
Aims and objectives		3
4. ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ:		4
ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР:.....		4
5. ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА:		6
5.1.ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТ		7
7. ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ. Үнэлгээний зарчим:		9
ҮНЭЛЭХ АЖЛЫН ГРАФИК.....		9
9. ХИЧЭЭЛЭЭР АШИГЛАХ НОМ, СУРАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ:		11

1. Ерөнхий мэдээлэл, баталгаажилт

Хичээлийн хөтөлбөрийн нийтлэг загварыг ХИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2022 оны 01 сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

Эрх зүйн баталгаажилт

- Монгол Улсын Их Хурал, (2019), *Боловсролын тухай хууль*
- Монгол Улсын Их Хурал, (2002), *Дээд боловсролын тухай хууль*
- Монгол улсын Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/78 тушаалын хавсралт, (2014), *Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл, индекс*

1.1 Хичээлийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Хичээлийн судлах цаг, улирал

Хичээлийн нэр:	Тогтвортой хөгжлийн боловсрол			
Хичээлийн индекс:	ESD102			
Хичээлийн ангилал:	Сонгон судлах			
Хамрах хүрээ:	Бүх мэргэжлээр суралцагсад			
Хичээлийн багц цаг, хэлбэр:	2 кредит:	Лекц 16 цаг	Семинар 32 цаг	
		Лаборатори ... цаг	Бие даалт 48 цаг	
Судлах улирал:	III			

Хүснэгт 2. Хичээл заах багшийн мэдээлэл

Тэнхим	ГХСС, МХУЗ
Багшийн нэр, цол, зэрэг	Т.Одончимэг, дэд профессор, доктор Б.Цэрэндаваа, дэд профессор, доктор
Багшийн цахим шуудангийн хаяг	odonchimegtumee@gmail.com
Оюутанд зөвлөгөө өгөх өдөр, цаг	Пүрэв, 15:00

1.3 Хөтөлбөрийн баталгаажилт

ГХСС-ын тэнхимийн 20... оны .. сарын ... -ны өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

Баталгаажуулсан:

Хөтөлбөрийн дэд хорооны ахлагч _____ гарын үсэг Б.Гүндэгмаа /тайлал/

ХИС-ийн НХУС-ийн ХСХ-ны 20... оны .. сарын ... -ны өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

Баталгаажуулсан:

Хөтөлбөрийн салбар хорооны дарга _____ гарын үсэг Г.Пүрэвдорж /тайлал/

ХИС-ийн ХЕХ-ны 20... оны .. сарын ... -ны өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

Баталгаажуулсан:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга _____ гарын үсэг Ц.Пүрэвсүрэн /тайлал/

2. Хөтөлбөрийн¹ үндэслэл:

БСШУ-ны Сайдын 2014 оны 04 сарын 28-ны А/174 тоот тушаал², БШУЯ-ны Сайдын 2014 оны А/74 тоот тушаал, “Тогтвортой хөгжил-2030” олон улсын хөтөлбөр, Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлого, МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ – 2030, Алсын хараа2050, Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Тогтвортой хөгжил-Дээд боловсрол" улсын II зөвлөгөөний зөвлөмж, Насан туршийн боловсролын үндэсний төвөөс боловсруулсан Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөр, Ховд Их сургуулийн 2016-2024 оны хөгжлийн хөтөлбөр, Багшийн ажлын журам³, ХИС-ийн Бакалаврын улирлын шалгалтын журам⁴-ыг тус тус үндэслэн боловсруулав.

Хэрэгцээ

Өнөөгийн хүн төрөлхтөн урьд өмнө хэзээ ч байгаагүй их “өөрчлөлт”-ийн эрин үед амьдарч байна. Энэ нь зөвхөн байгаль орчинд гарч буй өөрчлөлт төдийгүй мөн нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт бууралтын тухай хоорондоо нарийн гинжин хэлхээнд орших хүний амьдралын бүх хүрээг хамарч байна.

Summary

This 3 ECTS course consists of 96 working hours in the semester /16 hours of lectures, 32 hours of seminars and 48 hours of independent work/. It contains video and audio lecture presentations, seminars-workshops, discussions and group work to achieve the learning outcomes. In order to be examined, students must have attended at least 70% of all compulsory course sessions, such as lectures, workshops and seminars. Student absences of more than 30% of the course sessions must be compensated via additional course assignments. Student will provide with video and audio lectures, presentations, seminar and workshop instructions, creative work guidelines, reading resource.

Target student audiences

bachelor students, majoring in teacher education

Aims and objectives

The course aims to give a broad introduction to Education for Sustainable Development practice and and knowledge how to implement SDGs in education. This includes an analysis of the phenomenon of sustainable development and how the concept is reflected in education policy documents and in educational practice contexts.

¹ **ХӨТӨЛБӨР/КИРРИКЛИОМ:** Хоорондоо уялдаа холбоо бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (хөтөлбөрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын аргазүй, суралцах, орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа, хамтын ажиллагаа), тодорхой шатны боловсролын зэрэг (degree) олгоход нийцүүлсэн оюутны суралцах хөтөлбөр.

(www.qualityresearchinternational.com/glossary/)

² БСШУС-ын тушаал, *Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага*, 2014. 04.28-ны өдрийн тоот

³ Ховд Их сургуульд мөрддөг дүрэм, журмын эмхэтгэл /2017/

⁴ ХИС-ийн Захирлын 2018.03.05-ны өдрийн А/33 дугаар тушаалын 1-р хавсралт /Бакалаврын улирлын шалгалтын журам/

3. ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО: Хүний хөгжил ба ёсзүй, Эрүүл мэнд ба амьдрах ухаан

4. ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ:

Дэлхийн нэгдсэн үндэсний байгууллагаас дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн 17 зорилгын 4-рт “Хүн бүрт чанартай боловсролыг тэгш оролцоотой хүргэх, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх” гэж, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичигт тусгасан нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүнийг хөгжүүлэх” зорилго дэвшүүлсэн бөгөөд тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох зорилгыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан байна. Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.7. “Тогтвортой хөгжлийн боловсрол” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон нийтэд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ хэмээн заасан байна.

Зорилго: Ирээдүйн багш нарт ТХ болон ТХБ-ын үзэл баримтлалыг судлуулснаар тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын талаарх мэдээлэл, мэдлэг, үзэл санааг хүргэн, түүнийгээ түгээн дэлгэрүүлэх, сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгах арга барилыг эзэмшүүлэхэд зориулагдсан. Их сургуулийн түвшинд ТХ/НХ /ТХБ талаарх мэдлэг, ойлголт, чадвар бүхий мэргэжилтэнг бэлтгэх, улмаар сургалт болон насан туршийн боловсролоор дамжуулан бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх, үндэсний чадавхыг дээшлүүлэх чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэнэ.

Зорилтууд:

- ТХ болон ТХБ-ын талаарх мэдлэгтэй болгох:
 - ТХ болон ТХБ-ын тухай концепциудтай танилцаж, дэлхийн хэмжээнд ТХБ-ын үзэл санааг хэрхэн нэвтрүүлж буй туршлагатай танилцах:
 - Бие дааж бүтээлчээр ажиллах, мэдлэг бүтээх болон амьдрах ухааны ур чадвартай болгох:
 - ТХБ-ыг шавь нартаа түгээх хүсэл эрмэлзэлтэй болгох:
- Тогтвортой хөгжлийн боловсрол хичээлээр төлөвших үнэт зүйл:
- Ардчилал, тэгш эрх, шударга ёсыг эрхэмлэдэг байх
 - Харилцааны ур чадвар сайтай багш байх:
 - Амьдрах ухааны ур чадвартай түүнийгээ сургах, түгээх чадвартай байх:
 - Монголын ирээдүйн иргэдийг хөгжүүлэх хүсэл, эрмэлзэлтэй байх:

ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН /CLOs/

ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР:

Мэдлэг:

- ТХ болон ТХБ-ын концепцийн талаар мэдлэгтэй болох
- ТХБ-ын шинэ стратегитай танилцах
- Тогтвортой хөгжилд хүрэх аргазүйг судлах
- ТХБ-ын үзэл санааг сургалтын хөтөлбөрт тусгах болон хэрэгжүүлэх аргазүйг судлах
- Багш ажил амьдралаа тогтвортой хөгжлийн боловсролын зарчмаар хөтлөх, залуу хойч үеийнхэнд сургалтаар дамжуулан юмс, үзэгдлийг холбоо хамааралд нь таньж мэдэх сэтгэлгээний арга барил, хандлага, бусдын үзэл бодол, байр суурийг хүндэтгэн шийдвэр гаргах ёсзүй, үйл ажиллагаагаа уялдуулах, зохицуулах арга ухаан эзэмшүүлэх

Чадвар:

- байгаль орчин, нийгэм соёл, эдийн засгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх болон амьдралын чанарыг сайжруулах талаар эргэцүүлэн, тунгааж бодох чадвар эзэмших

“Тотвортой хөгжлийн боловсрол” хичээлийн хөтөлбөр

- Тэгш байдал, нийгмийн шударга ёс, шийдвэр гаргалт, нөөцийн шударга хуваарилалтын зарчмаар суралцахуйн үйлийг хөтлөх
- Дүрслэх ба хийсвэрлэх, ургуулан бодох бүтээлч сэтгэлгээнд суралцах
- Тогтолцоот сэтгэлгээний аргаар асуудлыг шийдэх
- Бүтээлчээр хандаж мэдлэг бүтээх аргазүйд суралцах
- Амьдрах ухааны ур чадвар эзэмших
- Байгаль дэлхийтэй зөв зүйтэй харьцах, эко орчин бүрдүүлэх аргазүйд суралцах
- ТХБ-ыш түгээн дэлгэрүүлж буй дэлхий нийтийн туршлагаас суралцах
- Өөрийгөө үнэлэн хөгжүүлэх, тасралтгүй суралцах чадвартай байх

Хичээлийн суралцахуйн хандлага:

- Энэ хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг бие даалт болон хэлэлцүүлэг, эссэ хэлбэрийн даалгавруудаар бататган практикт хэрэглэж сурах, тасралтгүй боловсрох
- Судалгааны үр дүн, баримт нотолгоонд хүндэтгэлтэй хандах, багаар ажиллах
- Аналитик болон шүүмжлэлт сэтгэлгээнд суралцах
- Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх

Ерөнхий хандлага: Эх дэлхийгээ хайрлах хамгаалах үзэлтэй, ирээдүйн иргэдийг сургах чин эрмэлзэлтэй, харилцааны болон амьдрах ухааны ур чадвартай, гоозүйн мэдрэмжтэй, идэвхтэй бүтээлч, бие даасан сэтгэлгээ төлөвшинө.

Судлагдахууны тал	Ур ухааны тал
<ul style="list-style-type: none"> • ТХ болон ТХБ-ын талаарх ойлголт, концедци, зарчмууд, түүнийг хэрэгжүүлэх баримт бичгүүд • Орчин нөхцөлдөө үнэлгээ өгөх • Сургалтын хөтөлбөр дээр ажиллах ажиллах 	<ul style="list-style-type: none"> • Улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломж, арга замыг тодорхойлох • ТХБ-ын үзэл санааг тусгасан хөтөлбөр боловсруулж турших • Дэлхийн хэмжээний туршлагаас суралцах, бүтээлч хандлагатай байх

Хичээлийн суралцахуйн үр дүн (CLOs) үр дүнг дараах байдлаар үнэлнэ:

Суралцахуйн үр дүн (CLOs)	Суралцахуйн үр дүнгийн тайлбар	Үнэлгээний арга
Мэдлэг	ТХБ-ын үндсэн асуудлуудын талаар мэдлэг, тус салбарын судалгааны мөн чанар, хүчин зүйлүүдийг олж тогтоох мэдлэг эзэмших, өөрийн маьдарч буй орчиндоо хэрэгжүүлэх, ажиллахад шаардлагатай мэдлэг олох	Ярилцлага, харьцуулсан анализ, онолын мэдлэг хуваалцах
Чадвар	Хичээлийн агуулгад баримжаалан тодорхой практик судалгаанд анализ хийх, өөрийн санаа бодлоо илэрхийлэх,	Харьцуулсан судалгаанууд дээр анализ хийх, дүгнэлт бичих, өөр дээрээ болон өөр хоорондоо туршилт явуулах
	Тотвортой хөгжлийн зорилтууд боловсролын үйл ажиллагаа, хөтөлбөр, бодит байдалд хэрхэн тусаж буй талаар дүн шинжилгээ хийх,	Судалгаа хийх, ажиллах, дата цуглуулах чадварын үнэлгээ
	Тогтвортой хөгжлийн боловсролын онол, практик, бодлоготой холбоотой шинжлэх ухааны судалгааны материалыг судлан дүгнэлт гаргах	
	Тогтвортой хөгжлийн зорилт, үзэл санааг боловсролын хөтөлбөрт тусгах, бусдад хүргэх, тогтвортой амьдралын хэв маягийг бий болгох Тус хичээлээр өгөгдсөн сэдвүүдийн хүрээнд мэдээлэл цуглуулах, анхан шатны боловсруулалт хийх, судалгааны төрөл, хэлбэр дээр ажиллах, анализ хийх	
	Багшийн өгсөн судалгааны кейс дээр багаар ажиллах, дүгнэлт гаргах, хэлэлцүүлэг хийх	Багш, багийн гишүүдийн үнэлгээ

Хандлага	Онолын мэдлэгийг практикт хэрэглэх, хичээлээр үзсэн зарим арга, туршилтыг туршиж үзэх, эргэн тойрондоо тогтвортой амьдралын хэв маяг бий болгоход санаачлага гаргах,	Багш, багийн гишүүд, судалгаанд оролцогсдын үнэлгээ
	Аналитик, шүүмжлэлт сэтгэлгээг бий болгох хэвшүүлэх, багаар ажиллах, бусдын санаа бодолд хүндэтгэлтэй хандах	Ярилцлага, илтгэл, хэлэлцүүлэг

5. ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА:

№	Хичээлийн агуулга бүлэг сэдвээр	Агуулгын ерөнхий чиглэл
1	Дэлхийн тогтвортой хөгжлийн замнал ба шинэ стратеги	ТХ болон ТХБ-ын концепци, зарчмууд, дэлхийн хэмжээний тунхаг бичиг, харти, дүрэм, хөтөлбөрийг судлах
2	Тогтвортой хөгжлийн боловсрол ба суралцахуй	Боловсролын шинэ чиг хандлагыг ойлгох, өөрийн удирдлагатай суралцах, сэтгэлгээ, үйлдлээ өөрчлөх замаар ТХБ-ын цогц чадамжийг эзэмших, өөртөө болон байгууллагад, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд системтэй сэтгэлгээний үүднээс хандах зэрэг арга замуудад суралцан, бусдад тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх чадвартай болох
3	Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл,	Тогтвортой хөгжилд хүрэх гүүр болсон ногоон өсөлт, аль болох тухайн орчныхоо байгалийн материалыг ашиглан байгальдаа ээлтэй, хүн амын амьжиргааг дэмжсэн, үр өгөөж нь үйлдвэрлэлийн өртгөөс илүү байх ногоон үйлдвэрлэл, хэрэглээ, нөөцийг үр ашигтай ашиглахын ач холбогдлын талаар мэдлэг олгож, хэт их хэрэглээгээ хэрхэн багасгаж, амьдралын хэв маягаа байгальд ээлтэйгээр өөрчилж болох санаачилгыг эхлэх хүсэл эрмэлзлийг бий болгох
4	ТХБ ба Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй чадамж	Уур амьсгалын өөрчлөлт, энэ өөрчлөлтийн улмаас хүний амьдрал болон байгаль экологид учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, саармагжуулахад чиглэсэн бодлого, үйл ажиллааны талаар мэдэж, экосистемд түшиглэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглүүлэн өөрсдийн оруулах хувь нэмрийг тодорхойлох, бусдад нөлөөлөх, дэмжих, оролцох арга барил эзэмших.

5.1.ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТ

Нэгдүгээр улирал:

Долоо хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга, олгох мэдлэг, чадвар	лекц	семинар
I	Дэлхийн тогтвортой хөгжлийн замнал ба шинэ стратеги	Дэлхий гаргаг ба хүн хоёрын харилцааны ТҮҮХ, тогтвортой хөгжлийн үндэс, Тогтвортой хөгжлийн концепци бий болсон тухай, Тогтвортой хөгжлийн концепцын элементүүд, Тогтвортой хөгжлийн зарчмууд	2	2
II		Экологийн асуудлууд: усан мандлын өнөөгийн байдал, цөлжилт, ойгүйжилт, биологийн олон янз байдал, биологийн бохирдол, нөөц ба хог хаягдал, Экологийн мөр ба экологийн үүрэг хариуцлагын өдөр		2
III	Дэлхийн тулгамдсан байдал: хүрээлэн буй орчин, нийгмийн, эдийн засгийн асуудлууд	Ногоон тээвэр, ногоон их сургуулиуд, тогтвортой амжиргаа, Амьдралын тогтвортой хэв маяг, 3R систем болон олон R олонлог, экологийн тосгон Эрх тэгш бус байдал, Жендерийн тэгш бус байдал, Боолчлол, хотжилт, хүн амын өсөлт, хүн ба эрүүл мэнд, авилгал, хүнд суртал, шилжилт хөдөлгөөн, аюулгүй байдал, глобалчлал	2	2
IV		Эдийн засгийн өсөлт ба хэрэглээний орчин үеийн загвар, Эдийн засгийн хямрал ба ажилгүйдэл, Дэлхийн ядуурал, Даяаршил		2
V	Тогтвортой хөгжлийн боловсролын үндсэн асуудлууд	“Тогтвортой хөгжил” ба “Тогтвортой хөгжлийн боловсрол” ухагдахууны хам утга, үндсэн ойлголт Тогтвортой хөгжлийн боловсролын зарчим Тогтвортой хөгжил ба тогтвортой хөгжлийн боловсролын үйлийн замнал, өрнөл	2	2
VI		Тогтвортой хөгжлийн загвар ба тогтолцооны үүднээс сэтгэх шаардлага		2
VII	ТХБ ба цогц чадамж: багшлахуй ба суралахуй	Боловсролын бодлогын парадигм “Цогц чадамж” (competencies) ухагдахууны тухай Сургалтын хөтөлбөр боловсруулах үзэл баримтлал	2	2
VIII		Цогц чадамжийн загварууд ТХБ-ын цогц чадамжийн тухай Сургалтын хөтөлбөр систем болох нь ТХБ - тогтолцооны арга, сэтгэлгээ Тогтолцооны аргын ухагдахуунууд		2
IX	ТХБ-д шилжихүй	Суралцахуйн шинжлэх ухааны хөгжил Сурган хүмүүжүүлэх ухаан ба ерөнхий	2	2

		дидактик		
X		Суралцахуй ба багшлахуй Гадны удирдлагатай суралцахуйн давуу ба сул тал / Өөрийн удирдлагатай суралцахуйн давуу ба сул тал		2
XI	ТХБ ба уурын амьгалын өөрчлөлтөд дасан зохицохуй	Уур амьсгалын өөрчлөлт, түүний шалтгаан, үр дагавар Уур амьсгалын өөрчлөлтөөс нийгэм, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл чадварууд		2
XII		Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги Монгол орны хэмжээнд дасан зохицох арга хэмжээ, боломжууд УАӨ-д бэлчээрийн дасан зохицохуй Уур амьсгалын өөрчлөлтөд эрчим хүчний салбарын дасан зохицохуй Уур амьсгалын өөрчлөлтөд барилгын салбарын дасан зохицохуй УАӨ-д тээврийн салбарын дасан зохицохуй	2	2
XIII		Тогтвортой амьдралын хэв маяг Хүнсний тэмдэг, тэмдэглэгээ зохистой хэрэглээ, ухаалаг худалдан авалт Эрүүл хүнсний тухай ойлголт Эрчим хүчний хэрэглээ Ус, түүний хэрэглээ Байгальд ээлтэй гэр бүл Тогтвортой хотжилтыг бий болгох		2
	Тогтвортой хэрэглээ, тогтвортой үйлдвэрлэл, Тогтвортой хотжилт		2	2
XIV		Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах Хог хаягдалтай холбоотой хууль, эрх зүй Эко шошго Байгальд ээлтэй бизнес ба үйлдвэр		
XV	ТХБ ба иргэншил, нийгмийн үнэт зүйл, ёсзүй	Хувийн зохион байгуулалтын чадварууд Хүмүүс хоорондын харилцааны чадварууд Аюулгүй амьдрах Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх		2
XVI		Шүүмжлэлтэйгээр сэтгэж, сайн шийдвэр гаргаж амьдралаа төлөвлөх, Үр ашигтайгаар харилцах Эрсдэлээс хамгаалах чадвартай байх;	2	2
	Нийт		16	32

6. СУРГАЛТЫН АРГА, ХЭЛБЭРҮҮД

Суралцахуйн үр дүн	Хичээл явуулах арга	Хичээлийн хэлбэр
Мэдлэг	Онолд суурилсан ярилцлага	Лекцийг тонгоруу хэлбэр болон эвлүүлгийн аргаар тогтмол явуулах Харилцаанд суурилсан аргууд
Чадвар	Төсөлт, асуудал болон кэйст суурилсан сургалт	Семинар: Багт болон багаар ажиллах: Анализ, хэлэлцүүлэг, практик ажлуудад анализ хийх, уншиж судалсан зүйлдээ дүн шинжилгээ хийх, жишиг харьцуулалт хийх
Хандлага	Судалгаа буюу төсөлт суурилсан сургалт	Харьцуулсан анализ, судалгааны танилцуулга, хэлний судалгааны кэйс хэлэлцүүлэг, жишиг харьцуулалт хийх

7. ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ. Үнэлгээний зарчим:

- ✓ Бодтой байх
- ✓ Оновчтой байх
- ✓ Найдвартай байх. Үүний тулд урьдчилсан нөхцөл нь бодтой байх
- ✓ Оюутан үнэлүүлэх хэлбэр төрлөө сонгох боломжоор хангагдах

Юуг, яаж, хэн үнэлэх:

Өөрийн, хөндлөнгийн \багийн, бусдын, холимог\, түвшин тогтоох үнэлгээ хийгдэнэ. Хувиргах, ухагдахуунуудын сүлжээ үүсгэх, нөхөх, сонгох, багцлах... олон хэлбэрээр үнэлэх . Үнэлгээний хугацаа улирал тус бүрд дараах байдлаар үнэлнэ. Үнэлгээний үр дүнг оношлон, дараагийн сургалтын үйл явц, зорилгод тусгах болно. Үнэлгээг дараах байдлаар хийнэ.

ҮНЭЛЭХ АЖЛЫН ГРАФИК

№	Бие даалтын сэдэв	9-р сар				10-р сар			11-р сар				12-р сар				Оноо
		1-7	8-14	15-21	22-28	6-12	13-19	20-26	3-9	10-16	17-23	24-30	1-7	8-14	15-21	22-28	
1	Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл /бүтээлч ажил -1/											✓					10
2	Өөрийн сургуулийн орчинд ТХБ-ыг түгээх санаачлагат ажил өрнүүлэх /гэрлээ унтраая, хогоо хогийн савандаа хийе, бүх нийтийн кросс гүйлт, явган аялал, машингүй өдөр гэх мэт/						✓										10
3	Олон нийтийг хамруулан эх дэлхийгээ хайрлах талаар суратлчилгаа				✓												10

“Томвортой хөгжлийн боловсрол” хичээлийн хөтөлбөр

	хийх /Эх дэлхийн цаг гэх мэт/															
4	Хүн бүр нэг цэцэг өөрөө тарьж арчлах /бүтээлч ажил -2/			✓												10
5	ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх мэдээллийн хөтөч ажиллуулах /өөрийн үнэлгээ/				✓				✓					✓		20
7	Эссе бичих						✓						✓			10
10	Нийт оноо /О-1, О-2/	Сургалтын хугацаанд														70
11	Улирлын шалгалт / сэдэв хамгаалах: бүлгээр ажиллана/															30

8. ХИЧЭЭЛИЙН ҮР ДҮНГИЙН СУДАЛГАА, САЙЖРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ

Хичээлийн хөтөлбөрийн чанарыг үнэлэх, сайжруулах арга хэлбэр	Хугацаа
Тухайн хичээлийн талаарх мэдлэгийн талаарх харьцуулсан үнэлгээ	
Сэтгэл ханамжийн судалгаа: 1.Хичээлийн үр дүнгийн талаарх ярилцлага 2. Сургалтын албанаас авах сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 3. Оюутнуудын эссе бичих, бүтээлч ажлын агуулга, аргазүй, гүйцэтгэл болон үнэлгээнд анализ хийх	2023 оны 1 сарын эхээр оюутны тухайн хичээлээр олж авсан мэдлэг, ач холбогдолтой эсэх, оюутнууд тус хичээлийн агуулгаас гадна өөр ямар мэдлэг, чадвар олж авсан, тус хичээлийг судлахад гарсан бэрхшээл, мөн сул болон муу тал, хичээл явуулж буй хэлбэр, аргазүй, үнэлгээ цаашид багш болон оюутны зүгээс анхаарах зүйл зэрэг агуулгаар бүлгээр болон зарим оюутнуудтай ганцаарчилсан ярилцлага хийх.
Хичээлийн хөтөлбөрийн үр дүнгийн анализ, сайжруулах төлөвлөгөө	Дараагийн улирлын эцэст

9. ХИЧЭЭЛЭЭР АШИГЛАХ НОМ, СУРАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Т.Одончимэг. Тогтвортой хөгжлийн боловсрол. Лекц, дадлага хичээлийн гарын авлага. Ховд, 2019, 84 х.
- 2.Т.Одончимэг, Б.Ганжолоо. ТХ-ийн зорилтыг ЕБС-ийн гадаад хэлний хичээлд тусгах асуудалд. ХИС-ийн НХУС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 2021. 122-134 х.
Амьдрах ухааны гарын авлага-13 модуль, 2016
3. “Тогтвортой хөгжлийн зорилго 4- Боловсрол 2030” –ийг дэлгэрүүлж ойлгох нь .
Улаанбаатар, 2017
- 4.Тогтвортой хөгжил – Дээд боловсрол. Улсын хоёрдугаар зөвөлгөөний эмхтгэл, УБ, 2018
- 5.Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөрийн цахим хичээл, 2016
- 6.А. Leicht, J. Heiss and W. J. Byun (2018) “Issues and trends in Education for Sustainable development”. the United Nations Educational, Scientific and Cultural Organization, 7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France, 276 p, <https://www.voced.edu.au/content/ngv%3A79160>